ALTAICA сэтгүүлийн 2024 оны дугаарт эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авна



Эрдэмтэн судлаач та бүхнийг ***ALTAICA*** эрдэм шинжилгээний цуврал сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэхийг урьж байна.

ALTAICA сэтгүүлийг анх 2001 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Алтай судлалын салбараас санаачлан хэвлүүлсэн. Түүнээс хойш жилд нэг удаа тогтмол хэвлэх болж, эдүгээ 19 дугаар уншигчдын гарт хүрээд байна.

Эдгээр дугаарт нийтлэгдсэн өгүүллүүд нь агуулгын хувьд алтай судлал, тодруулбал, монгол-түрэг, монгол-манж, монгол-солонгос, монгол-япон хэлний харилцаа холбоо, тэдгээр ард түмний хэл аялгуу, бичиг үсгийн дурсгал, түүх соёлыг хамарна. Түүнчлэн гадаадын эрдэмтдийн бичсэн чухал, ховор бүтээлийн орчуулгууд нийтлэгдсэн. Сэтгүүлийн дугаар бүр «Шүүмж», «Мэдээлэл» гэсэн булангуудтай болно.

ALTAICA сэтгүүл нь 2014 оноос олон улсын цуврал сэтгүүлийн ISSN 2308-278X стандарт дугаартай хэвлэгдэж байна. Тус сэтгүүлийн редакцын зөвлөлд дэлхий дахинд нэр хүндтэй, алтай судлалын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, тус чиглэлээр тууштай судалгаа хийж байгаа эрдэмтэн судлаачид багтдаг.

Та бүхэн ***ALTAICA*** сэтгүүлд нийтлүүлэх өгүүллээ тавигдах **шаардлагын дагуу** бичиж, **altaica@mas.ac.mn** хаягаар ирүүлэн бидэнтэй холбоотой ажиллана уу.

Өгүүлэл хүлээн авах: 2024.01.20 – 2024.05.20
Редакцын зөвлөл хянан магадлах: 2024.05.21 – 2024.06.20
Сэтгүүлд тэнцсэн эсэхийг зохиогчид мэдэгдэх: 2024.07.01
Өгүүллийг засах: 2024.07.01 - 2024.08.01
Сэтгүүлийг хэвлэлд бэлтгэх, хэвлүүлэх: 2024.08.01- 2024.09.01

ӨГҮҮЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ерөнхий шаардлага:

- Шинжлэх ухааны үндэслэлтэй;
- Өөр хэвлэлд хэвлэн нийтлэгдээгүй;
- Монгол, англи, орос хэлээр бичсэн өгүүллийг хүлээн авна.

Өгүүллийн бүтэц:

- Бүтээлийн нэр (англи нэрийн хамт)
- Зохиогчийн нэр
- Хураангуй (100-150 үгтэй, монгол, англи хэлээр бичсэн байх)
- Түлхүүр үг (6-10 үгтэй, монгол, англи хэлээр бичсэн байх)
- 1. Удиртгал
- 2. Судалгааны арга зүй
- 3. Судалгааны хэсэг (гарчгийг бичсэн байх)
- 4. Судалгааны үр дүн (хэлэлцүүлэг)
- 5. Дүгнэлт
- Ном зүй гэсэн үндсэн хэсгүүдтэй байна.
- Талархал (шаардлагатай бол)
- Хавсралт (шаардлагатай бол)

Өгүүллийн хэлбэр:

Цаасны хэмжээ	A4
Хуудасны тоо	8-10
Цаасны хүрээ	Бүх талаас 25мм (дээд, доод, баруун, зүүн)
Фонт, хэлбэр	Times New Roman, үсгийн хэмжээ 11-pt
Мөр хоорондын зай	1.15 (space)
Гарчиг	Гарчиг болон судлаачийн мэдээллийг эхний хуудсанд бичнэ. Өгүүллийн нэрийг толгой үсгээр, тод хараар бичиж, дор нь баруун талд зохиогчийн овог нэр, улс, хот, ажил (сургууль, байгууллага)-ын нэрийг бичнэ.
Үндсэн болон дэд бүлэг гарчиг	Үндсэн хэсгийн нэрийг хуудасны төвд толгой үсгээр бичнэ. Дэд хэсгийн гарчиг нь хуудасны зүүн талд байрлах бөгөөд том үсгээр эхлэн, жижиг үсгээр бичнэ. Гарчгуудыг 1, 1.1, 1.1.1 гэх мэтээр дугаарлана.
Хүснэгт, зураг	Хүснэгт болон зураг нь нэгдмэл дараалсан дугаартай, агуулгаа тодорхойлсон нэртэй байх ёстой. Хүснэгтийн нэрийг дээр нь, зургийн нэрийг доор нь голлуулан бичнэ.
Зүүлт, тайлбар (footnote)	Үгийн тайлбар, засвар, залруулга, нэмж судлах материалуудын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй өгөх шаардлагатай бол хэрэглэнэ.

Эшлэл:

Аливаа эх сурвалжаас авсан мэдээллийг өгүүллийн үндсэн бичвэрт эшилнэ. Эшлэхдээ дараах загварыг баримтална. Үүнд,

1. Шууд эшлэхдээ:

40-өөс доош үгтэй бол хашилтад хийж, зохиогчийн нэр, он, хуудасны дугаарыг хаалтад дурдана. Жишээ нь: "*-kī*[2] бүтээвэр нь багаж зэвсэг, байдлыг заасан жинхэнэ нэрийг бүтээнэ" (Захаров, 1879: 73).

40-өөс дээш үгтэй бол хашилтад хийлгүй, эшилсэн хэсгийг бүхэлд нь догол мөр болгон налуу хэлбэрээр бичнэ. Жишээ нь:

> *Ертөнцийн бүх юм үзэгдэл эсрэг тэсрэг хоёр талын зөрчил тэмцлийн хүчээр орчин хөдөлж, хувьсан хөгжиж, бас тэдгээр хоёр талын нэгдлийн ачаар шүтэн барилдаж, оршин тогтнож байдаг түгээмэл зүй тогтолтой. Ертөнцөд эерэг сөрөг буюу арга билгийн талгүй ямар ч юм үзэгдэл байхгүй учраас тэдгээрийг судлахдаа бүрэлдүүлж байгаа элементүүдийн зөрчил тэмцэл, нэгдэл шүтэлцээг цогцоор нь анхаарч, "Ерөнхий тогтолцооны онол"-ын үүднээс тодорхойлох хандлага дэлхийн шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл болжээ* (Өнөрбаян, 2009: 35).

2. Шууд бус эшлэхдээ:

Утга санаагаар эшлэх (хураангуйлах, өөрийн үгээр найруулах зэрэг) бол зохиогчийн нэрийн ард тухайн бүтээлийн хэвлэгдсэн оныг бичиж хаалтад хийнэ. Жишээ нь: Оросын эрдэмтэн З.К. Касьяненко (1964) монгол хэлний нэрлэхийн тийн ялгалыг "тодорхойгүй тийн ялгал" хэмээн нэрлэх нь илүү оновчтой гэж үзсэн байдаг.

3. Нэг зохиогчтой бүтээлээс эшлэхдээ:

Нэг зохиогчтой, ижил онд хэвлэгдсэн бүтээлүүд бол хэвлэсэн оных нь ард а, б, в гэх мэтчилэн үсгээр дугаарлаж ялгана. Жишээ нь: (Лувсанвандан, 1967а: 125, 1967б: 258).

4. Олон зохиогчтой бүтээлээс эшлэхдээ:

2 зохиогчтой бол 2 зохиогчийн нэрийг хоёуланг нь дурдана. Жишээ нь: (Мөнх-Амгалан; Кан Шин, 2002: 153).

3 ба түүнээс дээш зохиогчтой бол зөвхөн эхний зохиогчийн нэрийг дурдаж, бусад зохиогчийг "ба бус" гэсэн үгээр товчилно. Жишээ нь: (Баяртуяа ба бус., 2023: 114).

Олон зохиогчийн бүтээлийг нэг зэрэг эшлэх тохиолдолд он дарааллаар бичнэ. Жишээ нь: (Воробьев, 1935: 64; Ринчен, 1964: 17; Norman, 2003: 48; Kuribayashi, 2007: 56).

5. Гадаад хэлээр хэвлэгдсэн бүтээлээс эшлэхдээ:

Агуулгыг монгол хэлээр орчуулан эшилж, зохиогчийн нэрийг тухайн хэлээр нь бичнэ. Жишээ нь: (Johnson, 1987: 302).

Ном зүй:

Ном зүйн жагсаалтад зөвхөн эш татсан эх сурвалжийг оруулна. Ингэхдээ дугаарлахгүй, монгол ба гадаад хэлээр гэж ангилан, цагаан толгойн үсгийн дарааллаар бичнэ. Ном зүйг үйлдэхдээ дараах загварыг баримтална. Үүнд,

1. Ном, эмхэтгэл, хамтын бүтээл:

Ном бол:
Болд, Л. (2023). *Монгол түрэг хэлний харьцааны асуудалд*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК. [Bold, L. (2023). *On the Issue of the Relationship between Mongolian and Turkic Languages.* Ulaanbaatar: Soyombo LLC.]

Эмхэтгэсэн ном бол:
Очирцэнд М., Энхбадрах С. (эмх.), (2021). *Монгол хэл бичгийн бодлогын баримт бичгийн эмхэтгэл.* Улаанбаатар: Линограф. [Ochirtsend M., Enkhbadrakh S. (comp.), (2021). *Collection of Mongolian Language and Writing Policy Documents.* Ulaanbaatar: Linograf.]

Хамтын бүтээл бол:
Монгол хэл судлал. (2022). *Монгол хэл судлал.* IV боть. Ер.ред. Д. Заяабаатар. Улаанбаатар. [Mongolian Language Studies. (2022). *Mongolian Language Studies.* Volume IV. Ed-in Chief. D. Zayabaatar. Ulaanbaatar.]

2. Өгүүлэл:

Сэтгүүлд нийтлэгдсэн бол:
Чой Дон Гүэн. (2002). Манж хэлний өгүүлбэр төгсгөх -mbi нөхцөлийн гарлын тухайд. *Altaica,* II. Х. 45-55. [Choi Don Guen. (2002). About the Derivation of the Sentence Ending Suffix -mbi of the Manchu Language. *Altaica,* II. P. 45-55.]

Эмхэтгэл, эсвэл хамтын бүтээлд хэвлэгдсэн бол:
Новикова, К.А. (1979). Названия домашних животных в тунгусо-маньчжурских языках. *Исследования в области этимологии алтайских языков.* Отв.ред. В.И. Цинциус. Ленинград. Х. 53-134. [Novikova, K.A. (1979). Names of Domestic Animals in the Tungus-Manchu Languages. *Research in the Field of Etymology of Altai Languages.* Ed. Tsintsius V.I. Leningrad. P. 53-134.]

Цахимаар байршсан бол:
Humbley, J. (2009). Accounting for term formation. *Terminology Science and Research* 20. URL: http://lipas.uwasa.fi/hut/svenska/iitf/tsr2005/vol20/. (хандалт хийсэн огноо: 2023.06.15)

Холбоо барих утас: 91010011
ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Харьцуулсан хэл шинжлэлийн салбар

2024.01.19